

ХАРЬЦАЛ БҮТЭЭВЭРИЙН ТОГТОЛЦООГ СУДЛАХ ОНОЛ-АРГАЗҮЙН АСУУДАЛД

Д.Цэрэнпил¹

Монгол хэлний хэлзүйн үзэгдлүүдийн учирзүйн мөн чанарыг эрдэм шинжилгээний үүднээс зөв зүйтэй танин мэдэхэд харьцал бүтээвэрийн² тогтолцоог нээн гаргах зорилт чухал холбогдолтой юм. Үүний тулд хэл шинжлэлийн тэргүүний үзэл онолд суурилсан онол-аргазүйн зөв байр сууринаас хандах нь чухал.

Харьцал бүтээвэрийн тогтолцоог судлах хэл шинжлэлийн орчин нь өгүүлбэр юм. Өгүүлбэрийг тогтолцоот бүтэц бүхий цогц (системно-структурное образование) [Солнцев, 1977] гэж үзвэл тэр нь аливаа тогтолцооны нэгэн адил тодорхой тооны махбодиудаас тогтох бөгөөд тэдгээр нь тодорхой холбоо хамааралд оршдог гэсэн онол-арга зүйн үзэл баримтлал орчин үеийн өгүүлбэрзүйн судлалд голлож байна. Энэ үзэл онолыг “Тогтолцоот бүтэцийн хандалгын үүднээс авч үзвэл аливаа хэлэнд өгүүлбэр гэдэг нь тодорхой хэмжээгээр зохион байгуулагдсан зүйл буюу, өөрөөр хэлбэл, тогтолцоо (систем) юм. Энэ тогтолцооны махбодиуд (элементүүд) нь үг бөгөөд үгсийн хоорондын өгүүлбэрзүйн холбоо нь системийн дотоод холбоог буюу тухайн өгүүлбэрийн бүтэцийг бүрэлдүүлдэг” [Солнцев, 1984.7] хэмээн томъёолож болно.

Акад. Ш.Лувсанвандан “бүтэц өгүүлбэр” гэсэн ойлголтыг монгол хэл шинжлэлд анх авч үзээд “Нөхцөл оролцож бүтээх өгүүлбэрийг бид бүтэц өгүүлбэр гэж нэрлэлээ. Бүтэц өгүүлбэр нь маш нарийн зохион байгуулалттай олон талтай байдаг учир хэлний бүтэцийг судлахад хамгийн чухал сонирхолтой нь бүтэц өгүүлбэр болно. Бид орчин цагийн монгол хэлний үг, нөхцөлийг шүүмжлэн хэлэлцэхдээ юуны өмнө бүтэц өгүүлбэрээр нь суурь болгон авч үзнэ” [1968.13-14] гэжээ. Үг, нөхцөл хоёроос бүтэх “бүтэц өгүүлбэр”-ийг нөхцөлөөр холбогдсон үгсийн гинжин хэлхээтэй зүйрлэж болно. Энэ гинжин хэлхээний гархи нь “Лувсанванданы үг” буюу “харьцааны үг”, гархисын хоорондхи холбоос нь “Лувсанванданы нөхцөл” буюу “харьцааны нөхцөл” гэж үзвэл бүтэц өгүүлбэрийг дараахи хэдэн шинжээр тодорхойлож болно. Үүнд:

1. Бүтэц өгүүлбэрт “харьцааны үг”, “харьцааны (харьцал) бүтээвэр хоёроос өөр бүрдүүлэгч байхгүй.
2. Бүтэц өгүүлбэрт нэг харьцааны үг нь нөгөө харьцааны үгтэйгөө зөвхөн харьцал бүтээвэрээр холбогдоно.

¹ Доктор, профессор. МУИС-ийн Монгол хэл, соёлын сургууль.

² Хэлзүйн утга илтгэхээс гадна өгүүлбэрзүйн харьцаа илтгэх бүтээвэрүүдийг “нөхцөл” бүтээвэрийн ангиас ялган “харьцал” бүтээвэр гэж нэрлэв. Харьцал бүтээвэрийн тухай үз: [Цэрэнпил, 2009]

3. Бүтэц өгүүлбэрт харьцал бүтээвэрээр холбогдоогүй харьцааны үг гэж байх ёсгүй. Өөрөөр хэлбэл, харьцааны үг нь өгүүлбэрт “үндэс хэлбэрээрээ” холбогдохгүй.
4. Нэг харьцааны үг нь нэг л харьцал бүтээвэрээр холбогдоно. Өөрөөр хэлбэл, тухайн өгүүлбэрзүйн орчинд нэг харьцааны үг нь нэгээс илүү захирагдах харьцаанд орохгүй.
5. Бүтэц өгүүлбэр нь ямагт хоёр бүрэлдэхүүнтэй байна. Өөрөөр хэлбэл, өгүүлэгдэхүүн, өгүүлэхүүнийг илтгэсэн хоёр харьцааны үг заавал байна.
6. Өгүүлэгдэхүүн, өгүүлэхүүний хоорондхи харьцаа нь өгүүлбэрийг өгүүлбэр болгож байгаа гол харьцаа бөгөөд өгүүлэхүүнд залгасан харьцал бүтээвэрээр илэрнэ.

Эдгээр санааг тусган монгол хэлний бүтэц өгүүлбэрийн анхдагч бүдүүвчийг дараахи графаар загварчилж болно. Үүнд, сумны эхлэл нь захирагдах харьцаанд буй харьцааны үгийг, сумны төгсгөл нь захирах харьцаанд буй харьцааны үгийг заана.



Би ном -ын сан(г) -аас ном -Ø ав -на

Үүнд:

- | | | |
|----------------|---|----------------------------------|
| R | - | харьцааны үг |
| r | - | харьцал бүтээвэр |
| R _s | - | өгүүлэгдэхүүн болох харьцааны үг |
| R _p | - | өгүүлэхүүн болох харьцааны үг |

Математик хэл шинжлэлд тодорхой нэг өгүүлбэрийн өгүүлбэрзүйн бүтэцийг графийн тусламжтайгаар загварчилан дүрслэх хялбар аргыг өргөн хэрэглэдэг. Монгол хэлний тухайд энэ аргыг хэрэглэх нь бүр ч тохиромжтой юм. Учир нь “зангилаа” (узел) гэж нэрлэх цэгүүдийн олонлигийг сумаар холбон “граф” хэмээх математикийн дүрсийг үүсгэх нь харьцааны үгсийг хооронд нь харьцал бүтээвэрээр холбож бүтэц өгүүлбэр үүсгэхтэй уг чанар нэг юм.

Ерөнхий хэл шинжлэлд нэгэн төрөлийн гишүүнгүй буюу энгийн, нийлмэл бус өгүүлбэрийн тухайд иймэрхүү маягаар бүтсэн графууд нь “мод” болдог ажээ [ЭСЮФ, 1984.163]. Орчин цагийн монгол хэлний бүтэц өгүүлбэрийн ерөнхий бүдүүвч нь “өгүүлбэрзүйн захируулах харьцааны мод” болох бүх шинжийг хадгалсан байдаг. Графийн онолд дараахи шинж бүхий графийг “мод” гэж нэрлэдэг. Үүнд:

1. Сум гараагүй зангилаа (түүнийг “язгуур” гэж нэрлэнэ) байна, гэхдээ зөвхөн ганцхан байна.
2. Язгуураас бусад зангилаа бүрээс зөвхөн ганц сум гарна.
3. Ямар нэг зангилаанаас сумын дагуу явсаар тэр зангилаандаа буцаж ирэх боломжгүй.

Үүнээс үзвэл орчин цагийн монгол хэлний харьцал бүтээвэрийн бүтэц-үүрэгийн тогтолцоог графаар дүрслэгдсэн бүтэц өгүүлбэрийн орчинд загварчилан гаргаж болно.

Бидний баримтлах өөр нэг зарчим бол харьцал бүтээвэрийн тогтолцоо нь хэлэхүйн хэрэглээнд бус хэлний бүтэцэд тодорхойлогдох явдал юм. Хэл, хэлэхүй

хоёрын хоорондын харьцааг зөв тайлбарлах нь хэлний мөн чанарыг гүнзгий ойлгоход чухал ач холбогдолтой болсон учир хэл шинжээчид энэ талаар онцгой анхаарч янз бүрээр тайлбарласаар иржээ. Хэлэхүй бол хэлний тогтолцооны үүрэг гүйцэтгэж буй хэлбэр юм. Өөрөөр хэлбэл, хэлийг харилцааны хэрэглүүр болгон ашиглаж буй хэлбэр юм. Тэгэхлээр хэл, хэлэхүйн хоорондын харьцаа нь хэлний бүтэц, түүний хэрэглээ хоёрын хоорондын харьцаа юм.

Ф. де Соссюр “хэл”, “хэлэхүй” гэсэн ойлголтыг эрс зааглан ялгах болсон үеэс хойш хэлний нэгж, хэлэхүйн нэгж гэж ялгах болсон. Ийнхүү эрс зааглан үзэх нь ихээхэн шүүмжлэлийг дагуулдаг (энэ тухай үз: [Мыркин, 1970]) боловч харилцааны хэрэглүүр ба түүний хэрэглээ гэсэн хоёр үзэгдэлийг тодорхойлж буй энэхүү “хэл, хэлэхүй” гэсэн хосмолжин ойлголт нь шинжлэх ухааны үзэл бодолын хөгжилийн үр дүн болон гарч ирэхдээ өөрөө орчин үеийн хэл шинжлэлийн үндсэн зарчимуудын нэг болжээ. Хэлэхүй бол хэлний хэрэглүүрийг тодорхой нэг мэдээлэл дамжуулахын тулд ашиглаж байгаа хэрэг юм гэж үздэг учираас хэлэхүйд хэлний нэгжүүд болон тэдгээрийг холбох хууль дүрэмийн зэрэгцээ хэлэхүйн өөрийнхи нь шинж чанарыг агуулсан зүйлс бас байх ёстой болдог. Үүнд, нэгдүгээрт, хэлэхүйг бүрэлдүүлж буй хэлний нэгжүүдийн бүх боломжит нийлэмжүүд, хоёрдугаарт, хэлэлцэгчийн тухай хэл шинжлэлийн бус өргөн мэдээлэл (нас, боловсрол, бичиг үсэгийн чадвар, хоолойн өнгө, эрүүл мэндийн байдал, сэтгэл санааны байдал г.м.) орно.

Энэ мэтийн мэдээлэл болон хэлэхүйд гарч ирдэг боловч хэл шинжлэлд авч судалдаггүй бусад олон үзэгдэлийг А.И.Смирницкий “хэлний бус үлдэгдэл” [1954.29-30] гэж нэрлэжээ. Хэлэхүй дэх “үлдэгдэлийн” тухай санааг бүр өмнөхи үеийн хэлшинжээчид ч тодорхой гарган тавьж байв. Тухайлбал, А.Гардинер ХХ зууны эхээр бичихдээ: “Ярьж бичихийн тодорхой үзэгдэл ”хэлэнд” биш ”хэлэхүйд” хамаарах тухай ярихдаа хэлний элемент гэж нэрлэгдэх бүх уламжлалт элементүүдийг яриа, бичигээс ялган авахад нэгэн зүйл үлдэгдэл хоцрох бөгөөд яригч этгээд түүний төлөө бүрэн хариуцлагыг хүлээх ёстой. Энэ үлдэгдэлийг л би “хэлэхүйн хүчин зүйл” гэж ойлгож байна “ [Звегинцев, 1960.16] гэж “Хэл, хэлзүйн хоорондын ялгаа” гэдэг бүтээлдээ бичиж байжээ. Энэ ойлголт, нэр томъёог ч орчин үеийн хэлшинжлэлд хүлээн зөвшөөрч дэмжиж байна [Солнцев, 1977.147]. Тэгэхлээр “хэлний бус үлдэгдэл” гэдэг нь хэлийг бүтээж буй чухам тэр зүйлийг хэлэхүйгээс “ялган авсаны” дараа үлдэж буй тэр зүйл юм.

Монгол хэл шинжлэлд хэл, хэлэхүйг тодорхой ялгах, хэлний тогтолцоог судлахдаа түүнийг хэлэхүй дэх “хэлний бус үлдэгдэлээс” ангид авч үзэх тухай асуудалыг акад. Ш.Лувсанвандан дэвшүүлэн тавьсан билээ [1968.3-4; 1973.22-28]. Монгол хэлний тухайд сул үг, аялга үг, холбоос үг зэрэг хэлний бүтэцэд шууд холбогдолгүй хэлэхүйн бүтээгдэхүүнийг хэлний тогтолцоот чанараас чөлөөлж бүтэц өгүүлбэрийн гадна авч үзэх нь зүйтэй гэсэн зарчмыг бид баримтлах хэрэгтэй. Мөн өгүүлбэрийн асуух, үгүйсгэх хэлбэрүүд нь нэг ёсондоо бүтэц өгүүлбэрийн хувиргалууд тул тэдгээр хэлбэрийг илэрхийлэгч хэрэглүүрүүд нь мөн л бүтэц өгүүлбэрийн гаднахи зүйл болно. Аргазүйн энэ зарчмыг баримтлан харьцал бүтээвэрийн тогтолцоог хэлэхүйн хэрэглээнд бус, хэлний бүтэцэд тодорхойлох нь чухал юм.

Аливаа олонлигийг олон талаас нь, янз бүрийн зорилгоор сонирхож болно. Бид харьцал бүтээвэрийн тогтолцоог судлахдаа түүний бүтэц-үүрэгийн талыг гол болгон авах ёстой. Ерөөсөө тогтолцоо (система) гэдэг нь янз бүрийн утгаар өргөн хэрэглэгддэг ойлголт юм. Ерөнхий шинжлэх ухааны энэ ойлголтыг ямар ч утгаар нь авч үзсэн ч

аливаа олонлигийн тодорхой нэгдэлийн тухай төсөөлөлийг өөртөө агуулсан байдаг. Тухайн тогтолцоонд авч үзэх олонлигийг уг тогтолцооны махбодиуд (элементүүд) гэж нэрлэдэг. Тогтолцооны аливаа махбодь нь өөрөө нийлмэл бүтэцтэй байж болох боловч тухайн тогтолцооныхоо хүрээнд цаашид үл задрах нэгж болдог [Овчинников, 1967.16-26]. Монгол хэлний харьцал бүтээвэрийн бүрэлдэхүүнийг тогтоохдоо энэ зарчмыг тууштай баримтлах нь зүйтэй.

XX зууны туршид бусад олон шинжлэх ухааны нэгэн адил хэл шинжлэлийн хөгжил нь бодит ахуйн (субстанциональная) үзэл баримтлалаас бүтэц-үүрэгийн (структурно-функциональная) үзэл баримтлалд шилжсэнээр тодорхойлогддог [Солнцев, 1977.7]. Аливаа нэгэн цогцын бүтэц нь түүний бодит ахуйгаас харьцангуй үл хамааран орших тухай үзэл олон том нээлт гаргахад түлхэц болсон төдийгүй мөн төөрөгдөлд хүргэсэн юм. Энэ нь ялангуяа бүтэцийн бодит ахуйгаас харьцангуй биеэ даасан байдалыг бүрэн үл хамаарал мэтээр авч үзсэн судалгаануудад ажиглагддаг.

Хэл шинжлэлийн түүхэнд хэлийг бүтэц-үүрэгийн талаас нь үзэх үзэл дэлгэрсэн нь юуны түрүүнд Ф. де Соссюр болон түүний “Ерөнхий хэл шинжлэлийн курс” [1933] хэмээх алдарт бүтээлтэй нь шууд холбоотой юм. “Хэл бол бодит ахуй биш харин хэлбэр юм” гэсэн Ф. де Соссюрийн гол баримтлалуудын нэг нь “бүтэц хэл шинжлэл” гэсэн ерөнхий нэрийн дор нэгдсэн хэл шинжлэлийн олон салбарын хөгжилийг хэдэн арван жилээр урагшлуулсан юм. Түүгээр ч барахгүй Соссюрийн олон үзэл баримтлалыг уламжлалт хэл шинжлэлийн янз бүрийн салбарт авч хэрэглэсэн билээ. Аливаа зүйлийн бүтэц болон үүрэгийг илүү сонирхон үзэх хандалгыг Соссюр маш хүчтэй илэрхийлж байлаа. Түүний олон үзэл баримтлалыг И.А.Бодуэн де Куртенэ уламжлан хөгжүүлсэн юм.

Ф. де Соссюрийн үзэл онолын гол санаа нь хэлийг бодит ахуй биш хэлбэр гэж хүлээн зөвшөөрсөн явдал гэдэгийг дээр хэлсэн. Өөрөөр хэлбэл, “хэл” гэсэн ойлголтод бүтэц, материаллаг авианы зохион байгуулалтыг оруулж үзээд харин уг авианы материйг оруулаагүй билээ. Ингэсэнээрээ авианы сонсогдох талыг хэлэхүйн үзэгдэл гэж үзээд хэл бол “бодит ахуйн хальснаас” чөлөөлөгдсөн цэвэр бүтээгдэхүүн гэж үзсэн. Ф. де Соссюрийн энэ тулгуур үзэл “бүтэц” хэмээх ойлголтыг хэт дөвийлгөн үнэлж түүнийг “уг юм” гэсэн ойлголттой адилхан болгож аливаа цогц бүрдэл нь түүний бүтэц л юм гэж хэт хийсвэрлэх туйлшралын эхлэлийг тавьсан гэж үздэг нь үнэн юм. Соссюрийн үзэл онолын гол хүч нь бүтэц, үүрэг, харьцааны мөн чанарыг онцгойлон авч үзсэнд орших боловч, нөгөө талаас, чухам үүнд л түүний онолын сул тал оршиж байлаа. Учир нь эдгээр хүчин зүйлийн үүрэгийг туйлшруулах нь цаашдаа хэлний бодит ахуйгаас холдоход хүргэсэн юм. Энэ нь Л.Ельмслевийн үзэл онолд [1960] төгс хэлбэрээ олсоныг бид мэднэ.

Хэлийг бүтэцийнхи нь талаас авч үзэх явдал Ф.де Соссюрийг хэлийг түүхэн үүднээс авч үзэхээс хам цагт авч үзэхэд хүргэсэн билээ. Хэлний аливаа үзэгдэлийн түүхэн хувьсал хөгжилийн зүй тогтол, явж ирсэн замыг мөшгөн хөөж, танин мэдэж болох бөгөөд харин хэлний үзэгдэлийн, тэр тусмаа хэлний хэлзүйн байгуулалын тогтолцоот чанар нь цуваа цагийн харьцаанд ямагт өөрчлөгдөн хувьсаж байдаг. Өөрөөр хэлбэл, цуваа цагийн харьцаанд хэлний хувьсал хөгжилийн зүй тогтолыг танин мэдэх, харин хам цагийн харьцаанд хэлний бодит байдалын тогтолцоог нээн гаргах ёстой гэсэн аргазүйн зарчмыг бид баримтлах ёстой.

Тийм ч учираас монгол хэлний харьцал бүтээвэрийн тогтолцооны тухай ярихдаа бид “орчин цагийн монгол хэлний ...”, “бүтэц-үүрэгийн тогтолцоо” гэсэн

тодотголуудыг хэрэглэх нь онол-аргазүйн талаасаа зарчимын ач холбогдолтой юм. Тогтолцоо нь бүтэц-үүрэгийн, хам цагийн холбогдолтой байхаас гадна хосмолжин (бинарный) байх нь чухал. Тогтолцоо нь ихэвчлэн нийлмэл нарийн цогц байдаг бөгөөд олон түвшин, зэрэг дэвээс тогтсон байдаг. Гэхдээ ямар ч түвшинд махбодиуд нь бие биетэйгээ эсрэгцэлдсэн, хосмолжин харьцаанд оршино гэж үзэх нь аргазүйн хувьд чухал юм. Нэг бүрдвэр аль нэг түвшиндээ 3 буюу түүнээс дээш хуваагдана гэж үзэх нь бүтэц-үүрэгийн тогтолцооны мөн чанар биш юм. Ингэж үзэх нь эсвэл түвшин сольсон алдаа, эсвэл шалгуур нь бодит бус, нэгэн утгагүй, эсвэл ерөөсөө бүтэц-үүрэгийн тогтолцооны гаднахи асуудал байдаг. Аргазүйн ийм үндэслэл нь хоосон цэцэрхэл огт биш, харин бодит тогтолцооны мөн чанарыг гүн гүнзгий, зөв зүйтэй, шинжлэх ухаанчаар нээн гаргах арга зам болно.

Орчин цагийн монгол хэлний харьцал бүтээвэрийн тогтолцоог жинхэнэ тогтолцоо гэдэг утгаар нь авч үзэх хэрэгтэй. Тогтолцоо гэж юу вэ, тэр нь ямар шинж чанартай байх вэ гэдэг нь аргазүйн хувьд чухал асуудал юм. Тогтолцоот хандалгыг зөвхөн хэл шинжлэлд бус янз бүрийн шинжлэх ухаанд хэрэглэх болсоноор тогтолцоонуудын ерөнхий онолын тухай эрдэм мэдлэгийн тусгай салбар бий болгоход хүрчээ [Садовский, 1974].

“Тогтолцоо” гэдэг нь харилцан харьцаанд орших махбодиудын нэгдэл юм гэдэг ойлголт их түгээмэл байдаг. Тухайлбал, “Тогтолцоо гэдэг нь тодорхой шинж чанар хийгээд хэлхээ холбоогоороо ямар нэгэн байдалаар журамлагдсан, үйл ажиллагааны болон оршин тогтнох хэлбэр нь харьцангуй бие даасан дотоод цогц нэгдэлээр тодорхойлогдох, харьцангуй тогтвортой нэгдэл бүхий (ямар ч шинж чанарын) хоорондоо холбогдсон махбодиудын олонлиг юм” [Тюхтин, 1968.48] гэж үздэг. Энэ талын үзэл бодолыг И.В.Блауберг, Э.Г.Юдин нарын “Тогтолцоо ба бүтэцийн судалгааны философийн асуудалууд” [1970] гэдэг өгүүлэлд нэгтгэн бичжээ.

Тэгвэл “тогтолцоо” гэдэг нь харилцан холбоонд орших махбодиудаас тогтсон бүхэл цогц бүрдэл юм [Солнцев, 1977.14]. Бүхэл цогц чанар бол тогтолцооны хамагийн чухал чанар юм. Ямар ч тогтолцоо нь тодорхой махбодиудыг агуулсан байдаг тул төрөл ангид хуваагдах чанар бол тогтолцооны өөр нэг чухал шинж юм. Хэл шинжлэлийн ном зохиолд тогтолцооны тухай бичсэн зүйлийг Г.П.Мельниковын тодорхойлолтоор дүгнэн хэлж болохоор байна. Тэрбээр бичихдээ: “Тогтолцоо гэдэг ойлголтод харилцан холбогдсон буюу харилцан нөхцөлдсөн бөгөөд жинхэнэ бодит ахуйд хувилсан, харилцаа холбооны (харьцааны) тодорхой бүдүүвч бүхий, өөрөөр хэлбэл, бүтэц бүхий хэсэгүүд болох махбодиудын дурын нийлмэл нэгдэлийг ойлгох хэрэгтэй. Тэгвэл “бүтэц” гэдэг нь хэдийгээр хамагийн чухал боловч тогтолцооны шинж чанаруудын зөвхөн нэг нь юм. Тогтолцооны хоёрдахи, багагүй чухал шинж чанар бол түүний бодит ахуй юм” [1967.98] гэжээ.

Дүгнэн хэлбэл, “тогтолцоо” гэдэг нь махбодиуд болон тэдгээрийн хоорондын харьцаануудын бүрдэл юм. Жишээ нь, бүтэц өгүүлбэрийг нэгэн төрөлийн тогтолцоо гэж үзвэл түүний махбодиуд нь түүнд орсон харьцааны үгс, бүтэц нь харьцал бүтээвэрүүдээр илэрсэн харьцааны үгсийн хоорондхи өгүүлбэрзүйн харьцаануудын цогц юм.

Харьцааны үгсийн тогтолцоо болон түүнийг нөхцөлдүүлэгч гол хүчин зүйл болсон харьцал бүтээвэрийн тогтолцоог бүтэц-үүрэгийн талаас нь нээн гаргах зорилгын үүднээс орчин цагийн монгол хэлний тухайд (хам цагийн хүрээнд) дараахи үндсэн хоёр агуулгаар тодорхойлож болохоор байна. Үүнд:

1. **ТОГТОЛЦООНЫ МАХБОДИЙГ ТОДОРХОЙЛОХ.** Тогтолцооны махбодь нь тухайн тогтолцооны махбодиудын шинж чанарыг тодорхойлох шалгуурт нэгэн утгатайгаар тохирох, тухайн тогтолцооныхоо хүрээнд бусад махбодьтой ямар нэгэн тодорхой харьцаанд орсон байх, тухайн тогтолцооныхоо хүрээнд үл задрах тийм махбодь байх ёстой. Энэ шалгуурын дагуу орчин цагийн монгол хэлний харьцал бүтээвэрийн бүрэлдэхүүнийг нэгбүрчлэн, нарийвчлан тодорхойлох, түүнд юуг оруулах, юуг эс оруулах асуудалыг шийдвэрлэх хэрэгтэй.

2. **ТОГТОЛЦООНЫ БҮТЭЦИЙГ ТОДОРХОЙЛОХ.** Тогтолцооны бүтэц нь тухайн тогтолцооны махбодиудын хоорондхи бүх харьцааны цогц юм. Тогтолцооны судалгаануудад утгын хамгийн их ачаалал “харьцаа” гэсэн ойлголтод оногддог [Блауберг..., 1970.41]. Тогтолцооны тогтоц, зохион байгуулалт, эмх журамыг тухайн тогтолцооны “бүтэц” гэж нэрлэж байна. Хэл бол хоёрдогч материаллаг тогтолцооныхоо хувьд бүтэцтэй байх бөгөөд тэр нь уг хэлний дотоод зохион байгуулалт юм. Тогтолцооны бүтэц нь махбодиудын хоорондхи холбоо харьцааны шинж чанараар тодорхойлогддог. Тогтолцооны бүтэцийг тогтолцооны дотоод харьцаа холбооны нийлбэр гэж хэлж болно. Бүтэц нь зохион байгуулалтын тодорхой нэг хэлбэр болохын хувьд бодитойгоор орших бөгөөд тухайн тогтолцооны бодит ахуйгаас (махбодиос) ангид хийсвэрлэгдэн, биеэ даасан судлагдахуун болж болно. Орчин цагийн монгол хэлний харьцал бүтээврүүдийн бүтэц өгүүлбэрийн хүрээнд гүйцэтгэх үүрэгийг тодорхойлох нь тэдгээрийн бүтэц-үүрэгийн тогтолцооны бүтэцийг тодорхойлж байна гэсэн үг юм. Ингэхдээ уг бүтэцийн мөн чанарыг аль болохоор гүн гүнзгий, хэлзүйн цаад мөн чанараар нь, зөв оновчтой гаргах нь хамгийн чухал юм. Үүний тулд хэлзүйн үзэгдлүүдийн талаархи монгол хэлшинжлэлд хэвшин тогтсон олон зүйлийг шинэ соргог өнцөгөөс харах, шинэ санаа оноо дэвшүүлэх, улмаар монгол хэлний хэлзүйн байгуулалтын олон зангилаа асуудалтай холбогдсон ээдрээтэй, маргаантай асуудалуудыг хөндөхөд хүрч байна.

Нэг талаас, тогтолцооны махбодь болох харьцал бүтээврүүдийн бүрэлдэхүүнийг тогтоож, нөгөө талаас, тогтолцооны бүтэц болох тэдгээр бүтээвэрийн хэлзүйн үүрэгийг тодорхойлсоны үндсэн дээр уг тогтолцооны мөн чанарыг нээн гаргах онол-аргазүйн зөв үндэслэл баримтлах нь харьцал бүтээврүүдийн бүрэлдэхүүн, үүрэгийн шүтэн барилдсан нэгдэл болох тэдгээрийн бүтэц-үүрэгийн тогтолцоог хамгийн оновчтой танин мэдэх үндсэн нөхцөл болох юм.

ЭШ ТАТСАН НОМ ЗОХИОЛ

- Блауберг..., 1970 - И.В.Блауберг, Э.Г.Юдин, Философские проблемы исследования систем и структур - ВФ, 1970, №1
- Блауберг..., 1970а - И.В.Блауберг, В.И.Садовский, Э.Г.Юдин, Системный подход в современной науке - Проблемы методологии системного исследования, М., 1970
- Ельмслев, 1960 - Л.Ельмслев, Прологомены к теории языка - Новое в лингвистике, вып. I, М., 1960
- Звегинцев, 1960 - В.А.Звегинцев, Истории языкознания XIX и XX веков в очерках и извлечениях, часть 2, М., 1960

- Лувсанвандан, 1968- Ш.Лувсанвандан, Орчин цагийн монгол хэлний бүтэц. Монгол хэлний үг, нөхцөл хоёр нь, ШУАХ, УБ., 1968, 192х.
- Лувсанвандан, 1973- Хэл, хэлэх хоёрын учир – “Монголын судлал”, IX боть, 1973, х.22-28
- Мельников, 1967 - Г.П.Мельников, Системная лингвистика и ее отношение к структурной - Проблемы языкознания (Доклады и сообщения советских ученых на X международном конгрессе лингвистов), М., 1967
- Мыркин, 1970 - В.Я.Мыркин, Некоторые вопросы понятия речи в корреляции язык-речь, ВЯ, 1970, №1
- Овчинников, 1967 - Н.Ф.Овчинников, Категория структуры в науке о природе - Структура и форма материи, М., 1967
- Садовский, 1974 - В.Н.Садовский, Основания общей теории систем, М., 1974
- Смирницкий, 1954 - А.И.Смирницкий, Объективность существования языка, М., 1954
- Солнцев, 1977 - В.М. Солнцев, Язык как системно-структурное образование, М., 1977, 341 с.
- Солнцев, 1984 - В.М.Солнцев, Грамматическая структура и актуальное членение предложения - Восточное языкознание: грамматическое и актуальное членение предложения М., 1984
- Соссюр, 1933 - Ф. де Соссюр, Курс общей лингвистики, М., 1933
- Тюхтин, 1968 - В.С.Тюхтин, Системно-структурный подход и специфика философского знания - ВФ, 1968, №11
- Цэрэнпил, 2009 - Д.Цэрэнпил, Монгол хэлний харьцал бүтээвэр - “Монгол судлал”, МУИС.МХСС-ийн эрдэм шинжилгээний бичиг, XXX (318), 2009, х.112-124
- ЭСЮФ, 1984 - Энциклопедический словарь юного филолога, 1984, М.

РЕЗЮМЕ

В статье автор знакомит с теми теоретико-методическими принципами, которые рекомендуются им выявления сущности реляционных формантов сонгольского языка.

Основной средой для рассмотрения структурно-функциональной системы реляционных формантов служит структурная модель предложения или, как ее часто называют, “структурное предложение”, которое характеризуется следующими моментами:

- 1) Оно не имеет другого компонента, кроме реляционных слов и реляционных формантов.
- 2) В ней одно реляционное слово связано с другим только через реляционный формант.
- 3) В нем не может существовать реляционного слова несвязанного через реляционный формант.
- 4) В нем любое реляционное слово не может связаться через более чем один реляционный формант.

- 5) Оно имеет как минимум 2 обязательных компонента: реляционные слова как субъект и предикат
- 6) Оно строится на первичном для него отношении между субъектом и предикатом, которое выражается реляционным формантом, связанным с последним реляционным словом – предикатом.

Одним из довольно простых методов, широко применяемых в математической лингвистике является метод графа - различные способы точного описания синтаксического строения предложения с помощью графов. Графом в математике называют фигуру, состоящую из точек - их называют узлами графа, - соединенных стрелками. На взгляд автора удобно изучать структурное предложение в виде графа, поскольку оно, состоящее из реляционных слов (что и узлы), соединенных реляционными формантами (что и стрелки) точно напоминает граф в структурном плане. В общей лингвистике считается, что для предложений без однородных членов и не сложносочиненных, построенные таким образом графы являются "деревьями", что в полной мере можно отнести к общей схеме структурного предложения современного монгольского языка. "Деревом" в теории графов называют такой граф, в котором:

- 1) существует узел, и притом только один - называемый корнем, - из которого не выходит ни одна стрелка (что и подлежащее).
- 2) из каждого узла, кроме корня, выходит ровно одна стрелка.
- 3) невозможно, двигаясь из какого-нибудь узла в направлении стрелок, вернуться в этот узел.

Таким образом, средой для выявления структурно-функциональной системы реляционных формантов является изображенное графом структурное предложение.

Другим методологическим началом, которое придерживает автор, является то, что структурное предложение должно функционировать в языковой структуре, а не в речевом употреблении. Из утверждения, что речь есть функционирование языка, т.е. использование средств языка для передачи какой-либо информации, с неизбежностью следует, что в речи обнаруживается прежде всего то, из чего состоит язык как средство общения. Вместо с тем, в речи обнаруживается нечто помимо единиц языка и правил их соединения, которое определяется как "сверхязыковой остаток"³. О подобном "остатке" для монгольского языка говорил также акад. Ш.Лувсанвандан⁴. Поддерживая эту идею, автор очищает структурное предложение от таких сверхязыковых остатков.

Понятие "система" широко употребляется в самых различных значениях. Всякая система может интересоваться с разных точек зрения и в различных целях, но в сущности она должна быть:

- 1) структурно-функциональной. В современном языкознании все больше интерес проявляется к структурам и функциям объектов и его развитие характеризуется переносом внимания с субстанциональной точки зрения на структурно-функциональную. Распространение такой точки зрения на язык связывают в первую очередь с именем Ф. де Соссюра и его "Курсом общей лингвистики".
- 2) в синхронии. Структурно-функциональная точка зрения на язык побудила Ф. де Соссюра перейти от исторического рассмотрения языка к

³ А.И.Смирницкий, Объективность существования языка, М, 1954, 29-30; В.М.Солнцев, Язык как системно-структурное образование, М., 1977, 174

⁴ Ш.Лувсанвандан, Хэл, хэлэх хоёрын учир (О языке и речи) - МС 1 (9), 1973, 22-28

синхронному. Закономерности языковой эволюции распознаются в диахронии, тогда как система языковой статичности выявляется в синхронии, иными словами, о системности можно говорить только в синхронии.

3) бинарной. Говоря в точности, не сама система, а ее структура должна быть бинарной. Бинарность структуры – одна из характерных черт “настоящей системы”. Понятно, что мы имеем дело с довольно сложной и многоступенчатой структурой, поскольку система реляционных формантов определяет если не всю, то почти всю грамматическую природу монгольского языка. Но недаром, диссертант постарался сделать его систему только бинарной.

Неслучайно, что теоретико-методическая основа вытекает из самой сущности понятия системы. “Под системой следует понимать любое сложное единство, состоящее из взаимосвязанных и взаимообусловленных частей – элементов, воплощенных в реальную субстанцию и имеющих конкретную схему взаимосвязей (отношений), т.е. структуру”⁵. Это значит, чтобы знать систему надо сначала установить элементы, а затем выявить в каких отношениях они находятся между собой, т.е. определить структуру. Для нашей системы элементами выступают реляционные форманты, а структура определяется их синтаксической функцией в структурном предложении.

⁵ Г.П.Мельников, Системная лингвистика и ее отношение к структурной, Проблемы языкознания, М., 1967, 98